



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Хөрөнгийн залруулга хийх, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсгийг үндэслэн ТОГТООХ нь:

1. Төв аймгийн Угтаалцайдам сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд /орон нутгийн өмчид/ бүртгэлтэй 6,624,800.00 (зургаан сая зургаан зуун хорин дөрвөн мянга найман зуун) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан цаг уурын өртөөний барилгыг Төв аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн үндсэн хөрөнгөд давхар бүртгэснийг залруулж данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Төв аймгийн Ус, цаг уур орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Гэрэлцогтод дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгийн дансны залруулга хийх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу хийх;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Хууль тогтоолын үйлчилгээний газар

13201117

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 02 дугаар сарын 04-ны өдрийн
19 дугаар тогтоолын хавсралт

**ТӨВ АЙМГИЙН УС, ЦАГ УУР ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

Д/д	Үл хөдлөх хөрөнгийн нэр	Ашиглал- тад орсон он	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Угтаал цаг уур өртөөний барилга	1978	6,624,800.00	6,624,800.00	-
			(зургаан сая зургаан зуун хорин дөрвөн мянга найман зуу)		